



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: /УВА-2026/40/НА-СТА-ОНТС/

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2025 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Л.Шагдарсүрэн Утас: 91112518, Цахим хаяг: shagdarsuren1@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	9
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	9
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4.5.1 Завсрын аудитын талаар.....	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Э.НАСАНБАТ ТАНАА

2026.03.20 № УВА-2026/40/НА-СТА-ОНТС
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Увс аймгийн Авто замын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Авто замын сангийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

8525050550

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
335	Бусад авлага	0.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	0.00
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	0.00
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	0.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,573,286,600.0	1,188,900,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,573,286,600.0	1,188,900,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,573,286,600.0	1,188,900,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,573,286,600.0	1,188,900,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,573,286,600.0	1,188,900,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,573,286,600.0	1,188,900,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,515,869,994.0	1,159,199,798.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,515,869,994.0	1,159,199,798.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,515,869,994.0	1,159,199,798.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,416,606.0	29,700,202.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	57,416,606.0	29,700,202.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,416,606.00	29,700,202.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,573,286,600.0	1,188,900,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,573,286,600.0	1,188,900,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,573,286,600.0	1,188,900,000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,573,286,600.0	1,188,900,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,573,286,600.0	1,188,900,000.0

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,573,286,600.0	1,188,900,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,515,869,994.0	1,159,199,798.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,515,869,994.0	1,159,199,798.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,515,869,994.0	1,159,199,798.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,416,606.0	29,700,202.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	57,416,606.0	29,700,202.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,416,606.0	29,700,202.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,188,900,000.0	1,159,199,798	29,700,202.0	97.5%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Авто замын сан нь орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Авто замын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон журмыг баримтална.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэл өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Автозамын сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Автозамын сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Увс аймгийн Автозамын сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн данс байна.

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 356,670.2 мянган төгрөгөөр Буурснаар бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 356,670.2 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,188,900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Увс аймгийн Автозамын сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдааны 19 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар Аймгийн замын сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 9 төсөл арга хэмжээг 1,188,900.00 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,188,900.0 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 29,700.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71101-Авто зам 82214-Орон нутгийн чанартай авто замын засвар үйлчилгээ	1,188,900.0	1,159,199.8	29,700.2	97.5%
	Нийт дүн	1,188,900.0	1,159,199.8	29,700.2	97.5%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Авто замын сангийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдааны 19 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 1,188,900,0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим хуудсанд байршуулан худалдан авалтыг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс аймгийн Авто замын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Шагдарсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,188,900.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,889.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,511.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Авто замын сангийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорилыг хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Авто замын сангийн хувьд www.shilendans.gov.mn цахим хуудсанд тусгайлсан талбаргүй, харин шаардлагатай мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагчийн цахим хуудсанд байршуулдаг байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Авто замын сангийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байхгүй												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Байхгүй												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М. БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М. БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Д. ШАГДАРСҮРЭН/



2026 оны 03 сарын 20-ны өдөр